

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ГЭРЭЭ

/Ахуйн хэрэглэгч/

Гэрээг нэг талаас УБЦТС ТӨХК-ийг төлөөлж
.....Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн ажилтан
..... овогтой /цаашид **Хангагч** гэх/, нөгөө
талаас(дүүрэг, аймаг)-ын.....-р (хороо, сум)-
ын.....-р (хороолол,баг)-ын.....(байрны, гудамж).....тоотод оршин
суугч..... овогтой /цаашид **Хэрэглэгч** гэх/
нар Монгол Улсын “Иргэний хууль”, “Эрчим хүчний тухай хууль”, “Цахилгаан эрчим
хүч хэрэглэх дүрэм”, “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”,
“Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч- хэрэглэгч
хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”, Монгол Улсын стандарт “ Цахилгаанаар
хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага”-ыг үндэслэн
оны сарын –ээс жилийн хугацаатай дор дурьдсан
нөхцөлтэйгээр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Тус компанитай “Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ” байгуулах хэрэглэгч нь шугам сүлжээнд холбогдох техникийн нөхцөлтэй, цахилгаан эрчим хүчний төлбөрийн үлдэгдэлгүй, хэрэглэгчдийн мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг хийлгэсэн байна.
- 1.2 Энэхүү гэрээг үл хөдлөх хөрөнгө эзэмшигчтэй байгуулах тохиолдолд хамтран хариуцагчаар гарын үсэг зуруулж баталгаажуулна. Харин үл хөдлөх хөрөнгийг түрээслэгч, түр оршин суугчтай байгуулах тохиолдолд үл хөдлөх хөрөнгө эзэмшигч, өмчлөгчөөр заавал давхар гарын үсэг зуруулж баталгаажуулна.
- 1.3 Төлбөр тооцооны зөрчил, гэрээтэй холбоотой аливаа асуудлаар үл хөдлөх хөрөнгө эзэмшигч, хамтран хариуцагч, түрээслэгч, түр оршин суугч нар нэгэн адил эрх, үүрэг хүлээнэ.
- 1.4 Талууд энэхүү гэрээний үүргийг биелүүлэхтэй холбогдсон гэрээний нөхцөлд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын “Иргэний хууль”, “Эрчим хүчний тухай хууль”, “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”, “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”, “Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч - хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм”, Монгол Улсын стандарт “Цахилгаанаар хангагчаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний шаардлага” бусад хууль, тогтоомжийн заалтуудыг баримтлан шийдвэрлэнэ.

ХОЁР. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1 Хэрэглэгч нь “Эрчим хүчний тухай хууль”-д зааснаас гадна дараах эрхтэй.
 - 2.1.1. Монгол Улсад мөрдөгдөж буй стандартын шаардлага хангасан, хэрэглэгчийн зэрэглэлд нийцсэн цахилгаан эрчим хүчээр хангагдах
 - 2.1.2. Цахилгааны төлбөр төлөх хэлбэр, УБЦТС ТӨХК-ийн харилцдаг банкууд дотроос өөрийн харилцах банкаа сонгож гэрээнд тусгах /хавсралт №2/

- 2.1.3. Хангагчийн болон ажилтнуудын үйл ажиллагааны талаарх санал хүсэлт, гомдлыг УБЦТС ТӨХК-ийн дуудлагын 70047004 утсаар болон Хэрэглэгчдэд Үйлчлэх Төв (ХҮТ), Төв компани, удирдах дээд байгууллага, хууль, хяналтын байгууллагад мэдээлэх, гомдол гаргах
 - 2.1.4. Стандартын шаардлага хангаагүй цахилгаан эрчим хүч нийлүүлсэн тохиолдолд цаг тухайд нь хангагчид мэдэгдэж актаар тогтоогдсон хохирлоо нэхэмжлэх
 - 2.1.5. Цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэх хүсэлтээ хангагчид тавих эрхтэй бөгөөд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хэрэглэгч хариуцах
 - 2.1.6. Өөрийн эзэмшлийн шугам, тоног төхөөрөмжийн техник ашиглалт, аюулгүй ажиллагаа, засвар үйлчилгээ, шинэчлэлттэй холбоотой асуудлаар хангагчаас мэргэжлийн туслалцаа хүсэх, зөвлөгөө авах
 - 2.1.7. Өөрийн эзэмшлийн дэд станц, шугам тоноглолтой, хоёр талын цахилгааны эх үүсвэрээс тэжээлтэй болон автомат сэлгэн залгагч төхөөрөмж суурилуулсан, мөн аваарийн нөөц тэжээлийн эх үүсвэр /дизель, генератор/-тэй бол нэмэлтээр шуурхай ажиллагааны гэрээг байгуулан мэргэжлийн байгууллагаар үйлчлүүлэх
 - 2.1.8. Хэрэглэгч компанийн эзэмшлийн биш дэд станц, шугам тоноглолоос цахилгаан эрчим хүчээр тэжээгддэг бол засвар үйлчилгээний ажилд зөвөлгөө авах, төлбөрт үйлчилгээ хийлгэх
 - 2.1.9. Цахилгаан эрчим хүчээр хязгаарлуулсан зөрчлийг арилгасан бол Цахилгаан эрчим хүчээ сэргээлгэх хүсэлтийг харьяа Хэрэглэгчдэд үйлчлэх төвд биеэр болон 7004-7004 утсаар хүсэлтээ гаргана.
 - 2.1.10. Хангагчийн ажилтны буруугаас илүү төлбөр төлсөн, төлөх нөхцөл байдалд орсон бол цахилгаан эрчим хүчний бичилтийн залруулга хийлгэх, дараа сарын төлбөр лүү шилжүүлэх.
 - 2.1.11. Хангагч талын ажилтны бичиг баримтыг үзэх, шалгах
 - 2.1.12. 3 сар болон түүнээс дээш настай төлөгдөөгүй төлбөрөө төлөхдөөтөлбөрийн нийт дүнгийн 30 хувийг урьдчилан төлсөн бол авлага хэсэгчлэн барагдуулах гэрээ байгуулах хүсэлт гаргах.
- 2.2 Хэрэглэгч нь “Эрчим хүчний тухай хууль”-д зааснаас гадна дараах үүрэгтэй.
- 2.2.1. Хэрэглэгч өөрийн тухай мэдээлэл болон цахилгаан шугам, тоноглолынхоо схем, горим, зориулалт, хүчин чадал, үзүүлэлтүүдийг хангагчид үнэн зөв өгөх, мэдээлэлд өөрчлөлт орох тохиолдол бүрт цаг тухайд нь мэдэгдэж байх. Энэ тухай хангагчид мэдэгдээгүй бол үүсэх хохирлыг хангагч тал хариуцахгүй.
 - 2.2.2. Байр, орон сууц, хашаа, газрыг шинээр худалдан авсан, өвлөн авсан, бэлэглэлийн гэрээгээр авсан хэрэглэгч уг объектыг өмнө нь эзэмшиж байсан хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг өөрийн нэр дээр шилжүүлэн авах хүсэлтийг тухай бүрд нь хангагчид гаргах
 - 2.2.3. Эрчим хүчээр хангагчийн төлөөлөгчийг үйл ажиллагаагаа явуулах боломжоор хангах. Хангагчийн эрх бүхий ажилтныг өөрийн эзэмшлийн дэд станц, шугам тоноглолд орох, үйл ажиллагаа явуулахад саад учруулахгүй байх, дэд станцын хаалга, хашааны цоожны түлхүүрийг хоногийн 24 цагаар байнгын бэлэн байдалд байлгах

- 2.2.4. Эзэмшлийн заагаар цахилгааны шугам сүлжээ, дотор холболт, цахилгаан хэрэгслийн ашиглалт, аюулгүй ажиллагаа, галын аюулаас урьдчилан сэргийлэх шаардлагыг бүрэн хариуцах, цахилгаан шугам сүлжээ, тоног төхөөрөмжид аюул осол гарч болзошгүй нөхцөл бүрдсэн тохиолдолд хангагчид нэн даруй мэдэгдэх
- 2.2.5. Цахилгаан эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрмийг мөрдөх, өөрийн эзэмшлийн газарт байгаа цахилгаан шугам тоноглол, тэдгээрт очих замыг чөлөөтэй байлгах, кабель, агаарын шугамын хамгаалалтын зурваст газар шорооны болон бусад ажлыг хангагчийн зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэхгүй, бусдаар гүйцэтгүүлэхгүй байх
- 2.2.6. Өөрийн эзэмшлийн дэд станц, шугам тоноглолд ААД, ТАД-ын дагуу ашиглалт, үйлчилгээ, засварын ажлыг хийх бөгөөд эдгээр шугам тоноглолын ашиглалт, аюулгүй ажиллагааг хариуцсан мэргэжлийн ажилтныг томилон ажиллуулах эсвэл мэргэжлийн ажилтан, хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан байх
- 2.2.7. Хэрэглэгч нь нарийн мэдрэмжтэй тоног төхөөрөмж хэрэглэж байгаа бол гүйдэл, хүчдлийн хэлбэлзлээс хамгаалах төхөөрөмж тавьсан байх
- 2.2.8. Эрх бүхий байгууллагаар шалгагдаж битүүмжлэгдсэн тооцооны хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагааг алдагдуулахгүй байх
- 2.2.9. Цахилгаан эрчим хүчийг зүй зохистой ашиглаж, хэрэглэсэн цахилгаан эрчим хүчнийхээ төлбөрийг гэрээнд заасан хугацаанд бүрэн төлөх, хэрэглэгч төлбөрөө хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд 3 өдрийн дотор Хэрэглэгчдэд үйлчлэх төвд ирж асуудлаа шийдвэрлүүлэх.
- 2.2.10. Нөхөн тооцооны төлбөр, алданги, цахилгааны хэрэглээг түдгэлзүүлсэн, цахилгаан хангамжийг сэргээх, бусад үйлчилгээний төлбөр, сануулах, түдгэлзүүлэх болон шүүхэд шилжүүлэх мэдэгдэл хүргэсний хураамжуудыг зохих журмын дагуу төлөх
- 2.2.11. Цахилгаан шугам, тоноглолын техник ашиглалт, аюулгүй ажиллагааг хангуулах талаар түгээгчийн тавьсан шаардлагыг биелүүлэх
- 2.2.12. Өөрийн эзэмшлийн шугам тоноглолоос хангагчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдийг цахилгаан эрчим хүчинд холбохгүй байх, суурилагдсан хүчин чадал, хийц, зориулалтыг нь дур мэдэн өөрчлөх, өргөтгөхгүй байх.
- 2.2.13. Шугам тоноглолдоо автомат сэлгэн залгагч төхөөрөмж, мөн аваарийн нөөц тэжээлийн эх үүсвэр /дизель, генератор/ суурилуулах бол аюулгүй ажиллагааны үүднээс хангагчид заавал мэдэгдэж бүртгүүлэх
- 2.2.14. Хэрэглэгч нь 6-35 кВ-ын өндөр хүчдлийн шугам, тоноглол эзэмшдэг бол харъяа түгээх төвтэй “ЦАХИЛГААН ТОНОГЛОЛЫН НАЙДВАРТАЙ АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ”-г байгуулах
- 2.2.15. Хэрэглэгч нь 2.1.7-д заасан шугам тоноглолыг эзэмшдэг бөгөөд дэд станц, шугам тоноглол нь хоёр талын цахилгааны эх үүсвэрээс тэжээлтэй болон автомат сэлгэн залгагч төхөөрөмж суурилуулсан мөн аваарийн нөөц тэжээлийн эх үүсвэр /дизель, генератор/-тэй бол харъяа түгээх төвтэй “ШУУРХАЙ АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ”-г байгуулах
- 2.2.16. Цахилгаан сүлжээнээс салгуулах хэрэглэгчийн өргөдлийг шийдвэрлэх шаардлагатай хугацааг хангагчаас хэрэглэгчид хэлж, үйлчилгээний

- хураамж, тоолуурын заалтыг сүүлийн удаа авсанаас хойш таслалт хийгдэх өдөр хүртэлх цахилгааны төлбөрийн зөрүүг урьдчилан төлөх
- 2.2.17. Гэрээний хугацаа дуусах, өөрчлөлт орох, цикл өөрчлөгдсөн тохиолдолд хангагчийн мэдэгдсэнээр /албан тоотоор, утсаар, мэдээллийн самбараар/ хэрэглэгч Хэрэглэгчдэд үйлчлэх төвд биеэр ирж гэрээний өөрчлөлтийг харилцан тохирч гэрээнд тусгуулах.
- 2.2.18. Хэрэглэгчийн утасны дугаар өөрчлөгдөх бүрд хангагчид мэдэгдэж тэмдэглүүлэх.
- 2.2.19. Цахилгаан хангамж тасалдсан тохиолдолд хүний амь нас, улсын эрх ашиг, хэрэглэгчийн үйл ажиллагаанд ноцтой хохирол учирч болох онцлогтой хэрэглэгч өөрийн нөөц цахилгааны эх үүсвэртэй байна.

ГУРАВ. ХАНГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Хангагч нь “Эрчим хүчний тухай хууль”-д зааснаас гадна дараах эрхтэй.
- 3.1.1. Цахилгаан эрчим хүчний шугам, сүлжээний хамгаалалтын зурвас дотор хангагчийн зөвшөөрөлгүйгээр хашаа, байшин, барилга, гэр болон бусад объектыг байршуулсан хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчээр хангахгүй бөгөөд гэрээ байгуулахаас татгалзах
- 3.1.2. Авлагатай хэрэглэгчийн цахилгаан эрчим хүч сэргээх захиалгыг хүлээн авахгүй байх.
- 3.1.3. Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж холбох эрхтэй
- 3.1.4. Цахилгаан эрчим хүчийг зүй бусаар хэрэглэсэн хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг нөхөн тооцох, нөхөн тооцооны төлбөрийг нэхэмжлэх
- 3.1.5. Хэрэглэгч цахилгаан эрчим хүчний төлбөр, нэмэлт төлбөр, үйлчилгээний хураамж, нөхөн тооцооны төлбөрөө төлөөгүй, хангагчийн шаардлага, цахилгаан эрчим хүчээр хангах гэрээний заалтыг биелүүлээгүй бол төлбөрөө төлөхийг албан ёсоор шаардах, сануулах, түдгэлзүүлэх мэдэгдэл хүргэх. Хэрэглэгчийн эзэмшлийн шугам тоноглолын ашиглалт засвар үйлчилгээ болон энэхүү гэрээнд тусгагдсан бусад асуудалтай холбогдуулан хэрэглэгчид шаардлага тавих
- 3.1.6. Эрчим хүчээр хангагчийн эрх бүхий ажилтан “Эрчим хүчний тухай хууль”-ийн 32.2 дугаар заалтыг үндэслэн хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлэх
- 3.1.7. 3.1.5-д зааснаас гадна хэрэглэгчийн явуулж байгаа үйл ажиллагаа нь Монгол улсын хуулийг зөрчсөн, хүний амь нас, эд хөрөнгөнд хохирол учруулсан, хохирол учруулж болзошгүй нь Улсын байцаагчийн дүгнэлтээр нотлогдсон бол дээрх дүгнэлтийг үндэслэн цахилгаан эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлэх.
- 3.1.8. Хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж тасралт саатал, гэмтэл гарсан тохиолдолд дутуу түгээсэн цахилгаан эрчим хүчний үнэ болон бусад хохирлоо нэхэмжлэх

- 3.1.9. Хангагчийн горим ажиллагаа, цахилгаан эрчим хүчний чанарт сөрөг нөлөө үзүүлэх тоног төхөөрөмж ашиглахыг хориглох
- 3.1.10. Хангагч нь зайлшгүй шалтгааны улмаас хэрэглэгчийн бичилт хийлгэх, төлбөртооцоо хийх циклийн хугацааг өөрчлөх.
- 3.1.11. Хувийн эзэмшлийн трансформатортай хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний тооцоон дээр сар бүр трансформаторын хоосон явалтын энерги тооцож авах талаар мэдэгдэж гэрээнд тусгах.
- 3.1.12. Хангагч нь хэрэглэгчийн үүсгэсэн өрийн хэмжээ, шүүхийн захирамжийг хэрэглэгчид танилцуулан гэрээ цуцлагдсан болохыг мэдэгдэж УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн тооцооны хэмжих хэрэгсэл, кабелийг хураан авч акт үйлдэх.
- 3.1.13. Хэрэглэгчдэд үйлчлэх төвд ирж өр төлбөрөө барагдуулах арга хэмжээ авахгүй байх, авлага хэсэгчлэн барагдуулах гэрээний нөхцөл зөрчиж төлбөрөө төлөхгүй байгаа хэрэглэгчийг шүүхэд шилжүүлэх.
- 3.1.14. Цахилгаан эрчим хүчээр таслагдсан хэрэглэгчийн тасархай байдлыг 7 хоног тутамд хянах.
- 3.1.15. Зөрчилтэй хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчийг түдгэлзүүлэх тухай Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэл, дүүргийн тамгын газарбусад байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг үндэслэн хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчийг түдгэлзүүлэх/ энэ тохиолдолд түдгэлзүүлэхээс 3 хоногийн өмнө мэдэгдэх/

3.2 Хангагч нь “Эрчим хүчний тухай хууль”-д зааснаас гадна дараах үүрэгтэй.

- 3.2.1. Хангагч нь техникийн нөхцөл авсан, цахилгааны төлбөрийн үлдэгдэлгүй, зохих хураамж, төлбөрийг урьдчилан төлсөн хэрэглэгчтэй цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулж, өөрийн эзэмшлийн цахилгаан шугам сүлжээнд холбох
- 3.2.2. Хэрэглэгчийг Монгол улсын стандартын шаардлага хангасан цахилгаан эрчим хүчээр найдвартай хангах
- 3.2.3. Хэрэглэгчийн тухай мэдээллийн нууцыг чандлан хадгалах
- 3.2.4. Цахилгаан эрчим хүчийг нь хангагчийн зүгээс түдгэлзүүлсэн шалтгааныг шийдвэрлэн зөрчил устгах арга хэмжээг хэрэглэгч авсны дараа, үйлчилгээний төлбөр хураамжууд урьдчилан төлөгдсөн бол хангагч тал хэрэглэгчийн цахилгаан хангамжийг холбогдох журам, стандартад заасан хугацаанд сэргээх
- 3.2.5. Эрчим хүчний төлөвлөгөөт таслалтын талаар хэрэглэгчид 24-өөс доошгүй цагийн өмнө урьдчилан мэдэгдэх.
- 3.2.6. Өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийг гэмтээж, шатаасан бол өөрийн хөрөнгөөр засварлаж сэргээж өгөх
- 3.2.7. Ажилтны буруугаас хэрэглэгчийг илүү төлбөр төлүүлсэн, төлөх нөхцөл байдалд хүргэсэн бол алдааг залруулах, дараа сарын төлбөрт шилжүүлэх.
- 3.2.8. Хэрэглэгчийн бичилт төлбөр тооцооны циклийн хугацааг өөрчилсөн бол энэ тухай төлбөр тооцоо хийх хугацаа болохоос 14 хоногийн өмнө хэрэглэгчид мэдэгдэж гэрээнд бичгээр өөрчлөлт оруулах

- 3.2.9. Хэрэглэгчийн шугам тоноглолд гэрээ, хэлцлийн дагуу засвар үйлчилгээ, өргөтгөл шинэчлэлийн ажил хийсэн бол баталгаа гаргаж өгөх
- 3.2.10. Хэрэглэгч компанийн эзэмшлийн биш дэд станц,шугам тоноглолоос цахилгаан эрчим хүчээр тэжээгддэг бол засвар үйлчилгээний ажилд зөвлөгөө өгөх, төлбөрт үйлчилгээ үзүүлэх

ДӨРӨВ. ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨЛБӨР ТООЦООНЫ ЖУРАМ

- 4.1 Хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний зарцуулалтын тооцоог эрх бүхий байгууллагын баталгаажуулсан, хангагчийн ажилтны битүүмжилсэн тооцооны хэмжих хэрэгсэл, тоолуурын заалтыг баримтлан хийнэ.
- 4.2 Хэрэглэгчийн тоолуурын заалт авах үед тухайн тооцооны хэмжих хэрэгсэл гэмтэлтэй байгааг хангагчийн ажилтан илрүүлсэн бол тооцооны хэмжих хэрэгслийн гэмтэлд хэрэглэгчийн буруутай үйлдэл нөлөөлсөн эсэхийг тогтоож акт үйлдэнэ.
- 4.2.1. Тооцооны хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаа алдагдсанд хэрэглэгч буруутай буюу цахилгаан эрчим хүчийг зүй бусаар хэрэглэсэн болох нь тогтоогдвол “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 38 дугаар заалтыг үндэслэн хэрэглээг тооцно.
- 4.2.2. Тооцооны хэмжих хэрэгслийн гэмтэлд хэрэглэгч буруугүй тохиолдолд хэрэглэгчийн тухайн сарын хэрэглээг “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 39 дүгээр заалтыг үндэслэн сүүлийн 3 сарын тоолуурын заалтаар тооцсон хэрэглээний дунджаар тооцно.
- 4.3 Тооцооны хэмжих хэрэгслийг хангагч хэрэглэгчийн цахилгаан тоног төхөөрөмжийн эзэмшлийн зааг дээр тавина. Эзэмшлийн зааг дээр тоолуур тавиагүй тохиолдолд эзэмшлийн заагаас хэрэглээг тооцох цэг хүртэлх шугам болон трансформатор (ачааллын болон хоосон явалтын) дахь алдагдлыг шугам сүлжээг эзэмшигч хүлээнэ.
- 4.4 Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журам, гэрээний хүрээнд цахилгаан эрчим хүчний авлагагүй хэрэглэгчид цахилгааны үнийн хөнгөлөлт урамшуулал олгох болон нэмэлт төлбөр тооцож болно.
- 4.5 Төлбөрийн нэхэмжлэл гэрээнд заасан хугацаанд банк болон ХҮТ-ийн төлбөр төлөх цэгүүдэд хүргэгдсэн байна.
- 4.6 Төлбөрийн нэхэмжлэлд цахилгаан эрчим хүчний төлбөр тусгагдахаас гаднанөхөн тооцооны төлбөр, хугацаа хэтрүүлсний алданги, дараа төлбөрт үйлчилгээ үзүүлсэн бол үйлчилгээний төлбөр хураамж, НӨАТ, телевиз, хог хаягдлын хураамжийн төлбөрүүд бусад нэмэлт төлбөрүүд тусгагдсан байна.
- 4.7 Хэрэглэгч цахилгаан эрчим хүчний төлбөрөө банкинд болон банкны биллинг үйлчилгээ, картаар, дансаар, интернэтээр болон ХҮТ-ийн төлбөр төлөх цэгүүдээр бэлэн болон бэлэн бус хэлбэрээр төлнө.
- 4.8 Хэрэглэгч цахилгаан эрчим хүчний төлбөрөө урьдчилан төлж болно.
- 4.9 Хэрэглэгч нь хангагчийн төлбөрийн нэхэмжлэл банкинд хүргэгдсэнээс хойш гэрээнд заасан хугацаанд нэхэмжилсэн төлбөрийг төлөх бөгөөд энэ хугацаанд төлбөрөө төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутам 0.3% -ийн алданги төлнө.

- 4.10 Байр, орон сууц, хашаа, газрыг өмчлөгч, эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бусдад худалдах, бэлэглэх, өвлүүлэх, нүүн шилжих, түрээслэхдээ цахилгаан эрчим хүч хэрэглэсэн тооцоогоо хийж дуусган, энэ тухай тодорхойлолтыг хангагчаас авсан байна. Энэ тодорхойлолтыг тухайн байр, орон сууц, хашаа, газрыгшинээр өмчлөгч, эзэмшигч, түрээслэгч, бэлэглэлээр авагч, өвлөн авагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага шаардаж, гаргуулан авна. Хэрэв уг тодорхойлолтыг аваагүй тохиолдолд шинээр өмчлөгч, эзэмшигч эрчим хүчний өрийг хариуцна.
- 4.11 Хангагчтай гэрээ байгуулсан үл хөдлөх хөрөнгө өмчлөгч, эзэмшигч, түрээслэгч нас барсан, гадаад, дотоодод 3 сар ба түүнээс дээш удаан хугацаагаар нүүн шилжихдээ хангагчид мэдэгдээгүй, үл хөдлөх хөрөнгийг түрээслэгч нь цахилгаан хэрэглэсэн төлбөрөө барагдуулалгүй нүүн шилжсэн тохиолдлуудад энэхүү гэрээний 1.2, 1.3-д заасны дагуу хамтран хариуцагч төлбөр, тооцооны зөрчил гэрээтэй холбоотой аливаа асуудлыг хариуцан барагдуулна.
- 4.12 Хэрэглэгч техникийн үйлчилгээ авах бол тухайн үйлчилгээний төлбөр хураамжийг урьдчилан төлсөн байх шаардлагатай. Хэрэв хэрэглэгч техникийн үйлчилгээ хүсэх үедээ өмнөх 6 сарын турш цахилгаан эрчим хүчний төлбөр тооцоогоо хугацаанд нь хийсэн, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчөөгүй бол тухайн үйлчилгээний төлбөр хураамжийг дараа төлөх нөхцөлтэйгээр буюу дараа сарын цахилгааны төлбөрийн хураамж дээр нэмж төлүүлэхээр тохирч болно.
- 4.13 Энэхүү гэрээнд заагдсан үйлчилгээ, төлбөр хураамжийн тухай мэдээллийг ХҮТ-д биеэр ирж, эсвэл утсаар болон УБЦТС ТӨХК-ийн “Веб” хуудаснаас авч болно.
- 4.14 Зөрчилтэй хэрэглэгчдэд нөхөн тоцоо хийх ба хангагчийн эрх бүхий ажилтан нөхөн тоцооны акт үйлдэж төлбөрийг хэрэглэгчээр гарын үсэг зуруулж баталгаажуулна.

Үнэ тариф

- 4.15 Цахилгаан зарцуулалтын төлбөр тооцоог ЭХЗХ-ны Зохицуулагчдын Зөвлөлөөс баталсан хэрэглэгчдэд борлуулах цахилгааны үнэ тарифаар хийнэ.
- 4.16 ЭХЗХ-ны Зохицуулагчдын Зөвлөлөөс баталсан цахилгааны үнэ тариф өөрчлөгдөхөөс 15 хоногийн өмнө хэвлэл мэдээлэл, олон нийтийн хэрэгслээр шинэчлэгдсэн үнэ тарифыг зарласан байх бөгөөд 15 хоногийн дотор талууд гэрээнд өөрчлөлт оруулна. Гэрээнд өөрчлөлт оруулаагүй нь энэхүү үнэ тарифыг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй.
- 4.17 Үйлчилгээний төлбөр тооцоог ЭХЗХ-ны Зохицуулагчдын Зөвлөлөөс баталсан үнэ тарифын дагуу хийх бөгөөд угсралтын ажлыг төсвийн дагуу гэрээний үндсэн дээр хийнэ.

ТАВ. ТООЦООНЫ ХЭМЖИХ ХЭРЭГСЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 5.1 Хангагчийн эзэмшлийн дэд станц, нэгдсэн шитэнд байрлуулсан тооцооны хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангагч хариуцна.
- 5.2 Хэрэглэгчийн өмчлөлийн хашаа, байранд суурилуулсан хангагчийн эзэмшлийн тооцооны хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хэрэглэгч хариуцна.
- 5.3 Хэрэглэгчийн тооцооны хэмжих хэрэгслийг хангагч өөрийн эзэмшлийн тооцооны хэмжих хэрэгслээр солих хүртэлх хугацаанд хэрэглэгчийн тооцооны хэмжих хэрэгслээр цахилгаан эрчим хүчний хэрэглээг тооцох бөгөөд тооцооны хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хэрэглэгч хариуцна.
- 5.4 Хэрэглэгчийн эзэмшлийн тооцооны хэмжих хэрэгслийг баталгаажуулахтай холбогдон гарах зардлыг хэрэглэгч өөрөө хариуцна.
- 5.5 Баталгаажуулах хугацаанаас өмнө хэрэглэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас тооцооны хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагаа алдагдаж баталгаажуулах шаардлагатай болсон эсвэл хэрэглэгчийн хүсэлтээр тооцооны хэмжих хэрэгслийн ажиллагааг шалгаж баталгаажуулах тохиолдолд хэрэглэгч үйлчилгээний хураамжийг урьдчилан төлөх үүрэг хүлээнэ.
- 5.6 Хэрэглэгчийн тооцооны хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулах явцад тооцооны хэмжих хэрэгслийг оролдсон, гэмтээсэн шинж тэмдгүүдийг илрүүлсэн бөгөөд үүнд хэрэглэгчийн үйлдэл гарцаагүй нөлөөлсөн гэдгийг тогтоосон бол энэ тухай хэрэглэгчид мэдэгдэж хангагчийн эрх бүхий ажилтан акт үйлдэн, тооцооны хэмжих хэрэгсэл гэмтэлтэй байсан хугацаанд ногдох дутуу тооцсон цахилгаан эрчим хүчний хэрэглээг нөхөн тооцож нэхэмжилнэ.
- 5.7 Хангагчийн эзэмшлийн дэд станц, нэгдсэн шитэнд байрласан тоолуур хэмжих хэрэгслийн битүүмжлэл алдагдсан, дутуу тоолсон, эвдэрсэн гацсан алдагдсан бол энэхүү гэрээний 4.2.2 зүйлийг баримтлан дутуу тооцогдсон эрчим хүчийг нөхөж тооцно.
- 5.8 Тоолуур баталгаажуулах, солих үеийн тоолуургүй хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний тооцоог хэрэглэгчийн сүүлийн 3 сарын дундаж хэрэглээг тоолуургүй байсан өдрийн тоогоор үржүүлэн тооцож авна.
- 5.9 Хэрэглэгчийн баталгаажуулахаар авчирсан тоолуур нь компанийн эзэмшлийн бөгөөд, хулгайд алдагдсан тоолуур байвал шалгаж тогтоон тоолуурыг хураан авч алдагдсан нэгжид буцаана. Энэ тохиолдолд хэрэглэгчид учирсан хохирлыг хангагч хариуцахгүй.
- 5.10 Тооцооны хэмжих хэрэгслийн хэвийн ажиллагааг санаатайгаар удаа дараа алдагдуулж хангагчийн шаардлагыг биелүүлээгүй хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах ба шүүхийн байгууллагад шилжүүлнэ.
- 5.11 Өөрийн эзэмшлийн тоолуурт хэрэглэгч нь 2 сар дараалан хангагчийн эрх бүхий ажилтныг нэвтрүүлээгүй бол хангагч хэрэглээг түдгэлзүүлж хэрэглээг сүүлийн 3 сарын дунджаар тооцно. Нэвтрүүлээгүй тохиолдолд тэмдэглэл хөтөлж хөндлөнгийн гэрчээр баталгаажуулна.
- 5.12 Орон сууцны хэрэглэгчийн тоолуурыг давхар дундын нэгдсэн шитэнд байрлуулах ба хэрэглэгч гэр дотроо тавихыг хориглоно.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХАРИЛЦАН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 6.1 Тооцооны хэмжих хэрэгсэл алдагдсан, гэмтсэн тохиолдолд тооцооны хэмжих хэрэгсэл суурилуулах, гэмтэл устгахтай холбогдон гарах зардлыг тооцооны хэмжих хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг 5.1, 5.2-д заасан хариуцагч гаргана.
- 6.2 Хэрэглэгч цахилгаан эрчим хүчний төлбөрөө хугацаанд нь төлөөгүй бол гэрээнд заасан алдангийг төлөх бөгөөд хуулийн дагуу хангагч нь хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлнэ.
- 6.3 Цахилгаан эрчим хүчний тасалдал, чанарын үзүүлэлтийн хэлбэлзлээс болж хангагчтай гэрээтэй хэрэглэгчид хохирол учруулсан тохиолдолд 24 цагийн дотор хэрэглэгч хангагчид мэдэгдэж хамтарсан акт үйлдэн гаргасан шийдвэрийг үндэслэн шууд хохирлыг хариуцагч төлнө.
- 6.4 Цахилгаан эрчим хүчний тасалдлаас учирсан хохирлыг дор дурьдсан тохиолдолд хангагч хариуцахгүй.
 - 6.4.1. Байгалийн гэнэтийн аюул /аянга, салхи, шуурга, мөстлөг, үер, гал түймэр гэх мэт/ тохиолдсон
 - 6.4.2. Хангагчтай тохиролцсон горимыг хэрэглэгч мөрдөөгүйгээс хэрэглэгчийн цахилгаан хангамж тасалдсан
 - 6.4.3. “Эрчим хүчний тухай хууль”-ийн 29.1.2, 32.2-т заасны дагуу хэрэглэгчийн цахилгаан хангамжийг тасалсан, түдгэлзүүлсэн
 - 6.4.4. Хэрэглэгчийн цахилгаан дамжуулагч шугамыг гуравдагч этгээд гэмтээж эрчим хүчээр тасалдуулсан
 - 6.4.5. Хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан тасралт, саатал, гэмтэл гарснаас цахилгаан эрчим хүчийг түдгэлзүүлсэн
 - 6.4.6. 7-оос дээш хоногоор эзгүй байх тохиолдолд хангагчид мэдэгдээгүй.
- 6.5 Хэрэглэгч өөрийн буруутай үйлдэл мөн өөрийн өмчлөлийн буюу эзэмшлийн гэрийн тэжээвэр амьтдыг зохих хамгаалалтгүй байлгасны улмаас хангагчийн ажилтнуудад хохирол учруулсан бол холбогдох хууль, дүрмийн дагуу хохирлыг төлж барагдуулна.
- 6.6 Зар, мэдээлэл сануулгыг хэрэглэгчийн гэрээнд заасан нэр, хаяг, утасны дугаараар хүргүүлэх бөгөөд холбоо барих нэр, хаяг, утасны дугаар өөрчлөгдсөнийг хангагч талд албан ёсоор мэдэгдээгүй тохиолдолд гарах хохирлыг хангагч тал хариуцахгүй.
- 6.7 Хэрэглэгч нь хангагчийн хүлээн авах танхимын үзүүлэх үндсэн үйлчилгээнээс гадна ямар нэгэн ажил, үйлчилгээ авсан бол гэрээ хийсэн байх ёстой бөгөөд гэрээ хийгээгүй албан ёсоор баталгаажаагүй тохиолдолд үүссэн хохирлыг хангагч тал хариуцахгүй.
- 6.8 Хангагч нь хууль тогтоомж, гэрээнд заагаагүй нөхцөл шаардлага тавьж хэрэглэгчийн эрхийг хязгаарлахгүй байх.
- 6.9 Хэрэглэгчид гэрээний хугацаа дууссан болонгэрээнд өөрчлөлт оруулахаар мэдэгдэл өгөөд ирэхгүй байгаа нь хэрэглэгч үүрэг хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй

ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 7.1 Хангагч, хэрэглэгч талуудын хооронд гарсан цахилгаан эрчим хүчний хангамж, хэрэглээ, төлбөр тооцоотой холбогдсон маргаантай асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 7.2 Хэрэв харилцан тохиролцож шийдвэрлэж чадаагүй бол хэрэглэгчийн төлбөр тооцоотой холбоотой маргаантай асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ.

НАЙМ. ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ, ДҮГНЭХ, ЦУЦЛАХ

- 8.1 Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журамд өөрчлөлт орсон тохиолдолд гэрээг хугацаанаас нь өмнө шинэчлэн байгуулж болно.
- 8.2 Хангагч, хэрэглэгч талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд энэхүү өөрчлөлтийг бичгээр үйлдэж гэрээнд тусган баталгаажуулна.
- 8.3 Хангагч, хэрэглэгчийн хоорондын эзэмшлийн заагийг тодорхойлсон хавсралтыг техникийн нөхцөлд өөрчлөлт орсон тохиолдолд талууд заавал гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.
- 8.4 Хангагч, хэрэглэгч хоорондын эзэмшлийн заагийг тодорхойлсон НЭГДҮГЭЭР хавсралт, хэрэглэгчийн төлбөр төлөх хэлбэр, төлбөрийн хугацааг тодорхойлсон ХОЁРДУГААР хавсралт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 8.5 Гэрээний хавсралтуудад шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд хангагч утсаар болон бичгээр хэрэглэгчид мэдэгдэх бөгөөд заасан хугацаанд хэрэглэгч гэрээний хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулаагүй нь уг өөрчлөлтийг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй.
- 8.6 Хэрэглэгч гэрээ дуусахаас нэг сарын өмнө хангагчтай тооцоо нийлж, гэрээг дүгнэсэн протокол үйлдэнэ.
- 8.7 Гэрээг хоёр хувь үйлдэх ба талууд гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна. Талуудын хадгалсан хувь тус бүр нь нэгэн адил хүчин төгөлдөр байна.
- 8.8 Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг хуульд зааснаас гадна дараах нөхцөлд хугацаанаас нь өмнө цуцална.
 - Аль нэг талын санаачилгаар
 - Хэрэглэгч гэрээний үүргээ зөрчсөн, хангагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй бол
- 8.9 Гэрээ цуцлагдсан хэрэглэгч хангагчийн эзэмшлийн тооцооны хэмжих хэрэгсэлтэй бол хангагч тооцооны хэмжих хэрэгслийг хурааж авах бөгөөд хэрэглэгчийг дахин шугам сүлжээнд холбогдох боломжийг хязгаарласан техникийн арга хэмжээг авна.
- 8.10 Гэрээний хугацаа дуусахаас нэг сарын өмнө талууд гэрээ цуцлах санал гаргаагүй болон хэрэглэгч төлбөрийн зөрчилгүй байвал гэрээг анх заасан хугацаагаар гэрээ дүгнэсэн протоколыг үндэслэн дахин нэг удаа сунгагдсанд тооцно.
- 8.11 Тоолуур хэмжих хэрэгслийг хангагч байгууллагад мэдэгдэлгүй дур мэдэн солих, холболтыг өөрчлөх, битүүмжлэлийн 3 дугаар лацыг оролдох, тасалсан

үйлдлийг 3-аас дээш удаа үйлдсэн нь нотлогдвол нэг талын санаачилгаар гэрээг дуусгавар болгоно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН :

ХАНГАГЧ:

ХЭРЭГЛЭГЧ:

УБЦТС ТӨХК-ийн _____/Регистр дугаартай/

ХҮТ-ийнажилтан _____

овогтой _____

...../гарын үсэг/

/ _____ / Хамтран хариуцагч

Утас _____овогтой _____

...../Регистр дугаар/

_____ /гарын үсэг/

Хаяг

.....

.....

Түрээслэгч, түр оршин суугч

.....

/ _____ /

Утас:.....

НЭГДҮГЭЭР хавсралт

Хангагч, хэрэглэгч хоорондын эзэмшлийн зааг

1. Талуудын эзэмшлийн заагийг хувилбараар тогтоов.
Техникийн нөхцлийн дугаар огноо


Хэрэглэгчийн хүчний трансформаторын суурилагдсан чадал _____кВА

Хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн суурилагдсан чадал _____кВт

Гэрэлтүүлгийн чадал _____кВт

Нийлбэр чадал _____кВт

1.1 Тусдаа байрласан 0.4 кВ-ын хуваарилах самбараас болон орон сууцны ерөнхий щитнээс тэжээгдэж буй хэрэглэгчдийн шугам тоноглолыг зааглах схем



Эзэмшлийн зааг бичиглэлээр:

2.1 Цахилгаан эрчим хүчний тооцоо, төлбөр хийх хугацаа

Борлуулалтын цикл _____

Хэрэглэгчийн төлбөр төлөх тарифын ангилал _____

д/д	Агуулга	Хуанлийн өдрүүд
1	Сар бүрийн тоолуурын заалт авах өдөр	
2	Төлбөрийн нэхэмжлэл банк болон ХҮТ-ийн төлбөр төлөх цэгүүдэд очсон байх өдөр	
3	Тухайн сарын цахилгааны төлбөрөө төлсөн байх сүүлийн өдөр	
4	Алданги тооцож эхлэх өдөр	
5	Сануулах, түдгэлзүүлэх мэдэгдэл хүргэгдэх өдөр	
6	Эрчим хүчний хэрэглээг түдгэлзүүлж эхлэх өдөр	

2.2 Хэрэглэгчийн сонгосон банк

1. _____ банк _____ дансны дугаар

2. _____ банк _____ дансны дугаар

2.3 Хэрэглэгчийн төлбөр төлөх хэлбэр

- Дансаар..... /дансны дугаар/
- Картаар /биллинг/..... /картны дугаар/
- Бэлнээр / банк болон УБЦТС ТӨХК-ийнХҮТ-ийн кассанд төлнө.
- Интернэтээр

2.4 Хэрэглэгч цахилгаан эрчим хүчний төлбөрөө картаар буюу биллингийн үйлчилгээгээр төлөх бол доорх маягтыг бөглөнө үү. /Анхааруулга: Хэрэв тухайн хэрэглэгчийн картны үлдэгдэл төлбөр төлөхөд хүрэлцэхгүй тохиолдолд хангагчаас мэдэгдсэн даруй бусад хэлбэрээр төлбөрийг барагдуулна./

Хэрэглэгчийн овог нэр _____

Банкны нэр _____

Картын дугаар /16 оронтой дугаар/ _____

Картын хүчинтэй хугацаа _____

Хэрэглэгчийн банкны картнаас төлбөрийг суутган авахыг зөвшөөрсөн хэрэглэгчийн баталгаат гарын үсэг.

_____овогтой _____

/...../ огноо

2.5 Хэрэглэгчийн мэдээлэл авах хаяг / сануулах, түдгэлзүүлэх мэдэгдэл, төлбөртэй холбоотой бусад мэдээлэл/ Хэрэглэгчийн утасны дугаар өөрчлөгдөх бүрд хангагчид мэдэгдэж гэрээнд тусгуулах ба мэдэгдээгүй улмаас үүдэн гарах хохирлыг хангагч хариуцахгүй.

- ❖ Хэрэглэгчийн И-мэйл хаяг _____
- ❖ Хэрэглэгчийн утасны дугаар _____

2.6 Хэрэглэгчийн цахилгаанэрчимхүчнийхэрэглээнийзахиалга:

.....ОН

Хугацаа /сар/	Захиалга /кВт.ц/	Хугацаа /сар/	Захиалга /кВт.ц/
1 сар		7 сар	
2 сар		8 сар	
3 сар		9 сар	
Улирлындүн		Улирлындүн	
4 сар		10 сар	
5 сар		11 сар	
6 сар		12 сар	
Улирлындүн		Улирлындүн	
Эхнийхагасжилийндүн:		Сүүлийнхагасжилийндүн:	
Жилийдүн:			

.....онсарөдөр

ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан:

ХАНГАГЧ:

ХЭРЭГЛЭГЧ:

УБЦТС ТӨХК-ийн _____

ХҮТ-ийн.....ажилтан _____ хаягт
оршин суух

.....
/ _____ / / _____ /

ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

.....
.....
.....
.....
.....
.....

Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан:

ХАНГАГЧ:

ХЭРЭГЛЭГЧ:

УБЦТС ТӨХК-ийн _____

ХҮТ-ийн..... ажилтан
суух

_____ хаягт оршин

.....
/ _____ / / _____ /

ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

.....
.....
.....
.....
.....
.....
.....

Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан:

ХАНГАГЧ:

ХЭРЭГЛЭГЧ:

УБЦТС ТӨХК-ийн _____

ХҮТ-ийн..... ажилтан
оршин суух

_____ хаягт

.....

.....

/ _____ /

/ _____ /

ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

.....
.....
.....
.....
.....
.....
.....

Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан:

ХАНГАГЧ:

ХЭРЭГЛЭГЧ:

УБЦТС ТӨХК-ийн _____

ХҮТ-ийн..... ажилтан
суух

_____ хаягт оршин

.....

.....

/ _____ /

/ _____ /

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН ПРОТОКОЛ

№

.....онсарөдөр

Улаанбаатар хот

Хангагч:

Хэрэглэгч:

.....
.....

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

Шийдвэрлэсэн нь:

Хангагч:

Хэрэглэгч:

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

Гэрээ дүгнэсэн:

ХАНГАГЧ:

ХЭРЭГЛЭГЧ:

УБЦТС ТӨХК-ийн _____

ХҮТ-ийнажилтан

...../...../ _____ тоотод оршин суугч

Утас

.....

.....

/...../

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН ПРОТОКОЛ

№

.....онсарөдөр

Улаанбаатар хот

Хангагч:

Хэрэглэгч:

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

Шийдвэрлэсэн нь:

Хангагч:

Хэрэглэгч:

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

Гэрээ дүгнэсэн:

ХАНГАГЧ:

ХЭРЭГЛЭГЧ:

УБЦТС ТӨХК-ийн _____

ХҮТ-ийнажилтан

...../...../ _____ тоотод оршин суугч

Утас

..... /...../